


МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 03 өдөр

Дугаар A/159

Номгон


Хүн амыг Коронавируст халдварт (КОВИД-19)-ын
эсрэг вакцинаар дархлаажуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4, Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 05 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, дархлаажуулах үйл ажиллагааны удирдамжийг хоёрдугаар, нэгдсэн төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эсрэг вакциныг түгээх, дархлаажуулах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т, дархлаажуулах арга хэмжээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, албан байгууллага, иргэдийг татан оролцуулж, үйл ажиллагааг нь уялдуулан зохион байгуулахыг Цагдаагийн газар (Б.Оюутболд), Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж), Аймгийн Онцгой комиссын нарийн бичгийн дарга (Э.Батбаяр), Сумдын онцгой комиссын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын газар (Ж.Алтангэрэл)-т даалгасугай.



Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын
03-ны өдрийн А/159 дүгээр захирамжийн
1 дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: Э.Батбаяр - Онцгой комиссын нарийн бичгийн дарга

Нарийн бичгийн дарга: Н.Энхжаргал -Эрүүл мэндийн газрын дарга

Гишүүд: Д.Энхжаргал -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн дарга

Б.Оюутболд -Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа

Н.Бямбадорж - Мэргэжлийн хяналтын газрын дарга

Ц.Энхтөр - Боловсрол соёл, урлагийн газрын дарга

Ж.Мөнхсоёл - Баянхонгор сумын Засаг дарга

Э.Гүнжинлхам - Өрхийн Эрүүл мэндийн төвүүдийн холбооны тэргүүн/

П.Дүүрэнхундага -Хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагын холбооны
тэргүүн

Сумдын Засаг дарга нар

_____ооо_____

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын
03-ны өдрийн А/159 дүгээр захирамжийн
2 дугаар хавсралт



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЭСРЭГ ВАКЦИНААР ДАРХЛААЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл

Дархлаажуулалт нь халдварт өвчнөөс сэргийлэх хамгийн үр ашигтай, үр дүнтэй нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээ бөгөөд халдварт өвчний дэгдэлт, цар тахлын үеийн дарамт, үүссэн хор уршгийг багасгахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Манай улсад 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр Коронавируст халдвар (КОВИД-19)-ын анхны зөөвлөгдсөн тохиолдол, 11 дүгээр сарын 11-ний өдөр хүн амын “дотоодын халдвар” анх бүртгэгдсэн талаар зарласан.

Монгол улсын “Коронавируст халдвартын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний стратеги, төлөвлөгөө”-ний дагуу аймгийн нийт хүн амын 60%-ийг 2021 оны 3-р сараас эхлэн үе шаттайгаар коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах зорилгоор дараах төлөвлөгөөг боловсруулав.

Төлөвлөгөөний хүрээнд коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакциныг татан авах, ханган нийлүүлэх, хүлээн авснаас хойш 7 хоногийн хугацаанд дархлаажуулалтын нэгжид хүргэн, зорилтот бүлгийн хүн амыг богино хугацаанд вакцинжуулах, шинэ вакциныг хэрэглэх талаар олон нийт, салбар байгууллагуудыг мэдээллээр хангаж, салбар дундын хамтын оролцоонд тулгуурлан зохион байгуулна.

Хоёр. Зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

2.1. Зорилго:

2.1.1. Коронавируст халдвар(КОВИД-19)-ын эсрэг вакцин /цаашид “вакцин” гэх/-аар дархлаажуулах арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, өвчлөл, эндэгдлийг бууруулан, цар тахлыг хохирол багатай даван туулахад оршино.

2.2. Зорилт

2.2.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-т өртөх эрсдэлт бүлгийн хүн амыг тодорхойлон, нийт хүн амын 60%-ийн үе шаттайгаар богино хугацаанд аюулгүй дархлаажуулах.

2.

2.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааны чиглэл

2.3.1. Дархлаажуулах үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангах хүрээнд зорилтод бүлгийн тоон мэдээллийг бэлэн болгох.

2.3.2. Дархлаажуулалтын программ хангамжийн бэлэн байдлыг хангах.

2.3.3. Үйл ажиллагаанд оролцох хүний нөөцийг бэлтгэн, сургаж дадлагажуулах.

2.3.4. Вакцин дагалдах хэрэгслийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор дархлаажуулалтын нэгжид хүргэнэ.

2.3.5. Вакциныг дархлаажуулалтын нэгжид хүргэнсээс хойш 7-14 хоногт багтаан зорилтот бүлгийн хүн амыг вакцинуулна.

Гурав. Төрийн болон бусад байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ

Дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулахад дараах чиглэлийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.1. Онцгой байдлын газар

3.1.1. Вакцин, дагалдах хэрэгслийг тээвэрлэх, түгээх, дархлаажуулах явцад болзошгүй эрсдэл (цасан шуурга, зуд, үер гэх мэт байгалийн ноцтой үзэгдэл, тохиолдох, зам харгуй, машин эвдрэх, тог тасрах, гал түймэр гэх мэт) учирсан тохиолдолд асуудлыг шуурхай шийдвэрлэнэ.

3.1.2. Эрсдэлээс сэргийлэх, аюулгүй байдлыг хангахад бусад байгууллагын үйл ажиллагааг уялдуулан хамтран ажиллана.

3.2. Цагдаагийн газар

3.2.1. Вакцин татан авах, түгээх, хадгалах болон дархлаажуулалтын байнгын болон явуулын дархлаажуулалтын баг, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын аюулгүй байдлыг бүх түвшинд хангана.

3.2.2. Хууль бус жагсаал цуглаан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.2.3. Вакцин дагалдах хэрэгслийг хүлээн авах, тээвэрлэх явцад хамгаалалт гарган, тээвэрлэлтийн явцын мэдээллийг илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулах.

3.3. Мэргэжлийн хяналтын газар

3.

3.3.1. Вакцины бэлэн байдал, төлөвлөлт, нийлүүлэлт, вакцины чанар, аюулгүй байдал тээвэрлэлт, хадгалалт, дархлаажуулалтын явцад хяналт хийж, салбар хооронд хамтран ажиллана.

3.4. Орон нутгийн телевиз, цахим хуудас эрхлэгчид хэрэгжүүлэх арга хэмжээ

3.4.1. Дархлаажуулалтын үйл ажиллагааны талаарх үнэн зөв мэдээ, мэдээлэл, уриалгыг баталгаат эх сурвалжаас авч олон нийтэд үнэ төлбөргүй, саадгүй, шуурхай хүргэнэ.

3.5. Бүх шатны Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээ

3.5.1. Орон нутгийн хэмжээнд вакцин тээвэрлэх зорилтот бүлгийг дархлаажуулах үйл ажиллагааг сумын Онцгой комисс удирдан зохион байгуулна.

3.5.2. Аж ахуй нэгж байгууллага, иргэний нийгмийн байгууллага, сайн дурын идэвхтний оролцоог хангах, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, цаг үеийн нөхцөл байдлыг хэлэлцэн, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулна.

3.5.3. Дархлаажуулалтын үйл ажиллагааны зардал (тээврийн хэрэгсэл, шатахуун, томилолт, хоол, илүү цагийн хөлс, хувийн хамгаалах хувцас хэргсэл, харилцаа холбоо, дархлаажуулалтын түр болон байнгын цэг байгуулах байр зэрэг)-ыг тухай бүр шийдвэрлэнэ.

3.6. Эрүүл мэндийн газар хэрэгжүүлэх арга хэмжээ

3.6.1. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд салбар хоорондын байгууллагуудтай хамтран ажиллах, мэргэжил арга зүйгээр хангана.

3.6.2. Вакцин дагалдах хэрэгслийг татан авч, нэгжүүдэд шуурхай түгээх.

3.6.3. Хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн судалгааг дархлаажуулалтын нэгж, шатлал тус бүрээр гарган, багтаамжийг тооцох, тооцоололд үндэслэн шаардагдах багтаамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

3.6.4. Дархлаажуулалтын үйл ажиллагааны бичил төлөвлөгөө (вакцин татан авах, түгээх, ажиллах хүний нөөцийн судалгаа, ажиллах хуваарь, байнгын, явуулын, түр цэг байрлуулах зураглал, тээврийн хэрэгслийн төрөл, маршрут гэх мэт)-г боловсруулан хэрэгжүүлнэ.

3.6.5. Сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төв дархлаажуулалтын бичил төлөвлөгөө гаргасан эсэхэд хяналт тавьж, дархлаажуулах үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийн, удирдлага арга зүйгээр хангана.

4.

3.6.6. Дархлаажуулалтын үйл ажиллагаанд оролцох хүний нөөцийн судалгааг гаргаж, сургалтад хамруулан, ажил үүргийн чиглэлийг танилцуулах.

3.6.7. Олон нийтэд чиглэсэн мэдээлэл сургалт, сурталчилгаа хийнэ.

3.6.8. Аймгийн Онцгой комиссыг мэдээллээр хангана.

3.6.9. Дархлаажуулалтын нэгдсэн тайланг Халдварт өвчин судлалын үндэсний төвд хүргүүлнэ.

3.7. Сум, өрхийн эрүүл мэндийн төв

3.7.1. Байгууллага бүр дархлаажуулалтын үйл ажиллагааны бичил төлөвлөгөө (вакцин татан авах, ажиллах хүний нөөцийн судалгаа, ажиллах хуваарь, байнгын, явуулын, түр цэг байрлуулах зураглал, тээврийн хэрэгслийн төрөл, маршрут гэх мэт)-г боловсруулан хэрэгүүлнэ.

3.7.2. Зорилтот бүлгийн хүн амын мэдээллийг үнэ бодит гаргана.

3.7.3. Хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн багтаамжийг тооцох, вакциныг зохих хэмд хадгалах, тээвэрлэх онцгой анхаарч, авулгүй байдлыг бүрэн хангана.

3.7.4. Дархлаажуулалтын үйл ажиллагаанд оролцох хүний нөөцийн судалгааг гаргаж, ажилтан бүрт хийх ажлыг танилцуулан үүрэгжүүлэх.

3.7.5. Дархлаажуулалтын нэгжүүдийн тоо, байршил, зам, хоорондын зайд, тээврийн хэрэгслийн тооноос хамаарч хүний нөөцийн төлөвлөлт, дайчлан ажиллуулах төлөвлөлтийг хийсэн байна.


3.7.6. Дархлаажуулалтын хамралтын мэдээллийг цахим бүртгэлд бүртгэх тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангасан байна.

Дөрөв. Хяналт-шинжилгээ үнэлгээ

4.1. Вакцин түгээх тээвэрлэх, хадгалах, дархлаажуулалтын үйл ажиллагааны өмнө, явцад болон төгсгөлд дэмжлэгт хяналт, вакцины хамралтыг түргэвчилсэн үнэлгээгээр аймгийн Мэргэжлийн хяналтын байгууллагаас гүйцэтгэнэ.

4.2. Дэмжлэгт хяналт, вакцины хамралтын түргэвчилсэн үнэлгээний дүнг тухай бүр нь аймгийн Онцгой комисс болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд танилцуулна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын
03-ны өдрийн А/159 дүгээр захирамжийн
3 дугаар хавсралт



**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЭСРЭГ
ВАКЦИНААР ДАРХЛААЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1	2	3	4	5
Нэг. Вакцинжуулах үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах				
1	Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулах тухай УОК-ын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 05 дугаар тушаалтыг АОК-ын бүрэлдэхүүнд танилцуулах.	2021 оны 3 дугаар сарын эхний долоо хоног	Онцгой байдлын газар	Эрүүл мэндийн газар
2	Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулах аймгийн хэмжээний ажлын хэсгийг байгуулах.	2021 оны 3 дугаар сарын эхний долоо хоног	Эрүүл мэндийн газар	Онцгой байдлын газар
3	Коронавируст халдварт (КОВИД-19)-ын эсрэг вакциныг түгээх дархлаажуулах зорилтот бүлгийн судалгаа, үйл ажиллагаанд оролцох ажилтан албан хаагч, дайчлан ажиллуулах хүний нөөц, хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн нөөц, зохих шаардлагыг хангасан байнгын болон түр цэгийн мэдээллийг тусгасан бичил төлөвлөгөө боловсруулах.	2021 оны 3 дугаар сарын эхний долоо хоног	Ажлын хэсэг	Аймаг, сумдын Онцгой комиссын бүрэлдэхүүн

2.

1	2	3	4	5
4	Нийт хүн амын дунд эрэмбэлэн ангилалт хийж, зорилтот бүлгийн хамрагдвал зохих хүн амын судалгааг гаргах.	2021 оны 2 дугаар сар	Эрүүл мэндийн газар	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
5	Вакцины хөргөгч болон тээвэрлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, хуурай бэлэн агуулахын байдлыг хангах.	2021 оны 1 дүгээр сар	Эрүүл мэндийн газар	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
6	Хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн багтаамж, нөөц, хэм хяналтын хэрэгсэл, хуурай агуулахын багтаамжийг үнэлж, шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх.	2021 оны 1 дүгээр сар	Эрүүл мэндийн газар	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
7	Аймгийн хэмжээнд дархлаажуулалтын үйл ажиллагаа зохион бичил байгуулах төлөвлөгөөг танилцуулах.	2021 оны 3 дугаар сар	Ажлын хэсэг	Аймаг, сумдын Онцгой комиссын бүрэлдэхүүн
8	Дархлаажуулалтын цахим програмын бэлэн байдлыг хангах.	2021 оны 3 дугаар сар	Эрүүл мэндийн газар	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
9	Вакциныг түгээх, дархлаажуулах үйл ажиллагаанд оролцох ЭМА болон бусад салбарын албан хаагчийг сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.	2021 оны 3 дугаар сар	Эрүүл мэндийн газар	Мэргэжлийн хяналтын газар Онцгой байдлын газар, Цагдаагийн газар Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
10	Халдвараас сэргийлэх хяналтын дэглэмийн шаардлага хангасан дархлаажуулалт хийх түр цэгийг байгуулах аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гаргаж, бэлэн байдлыг хангах.	2021 оны 3 дугаар сар	Ажлын хэсэг	Аймаг, сумдын Онцгой комиссын бүрэлдэхүүн

3.

1	2	3	4	5
11	Дархлаажуулалтын үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг тооцож, аймгийн ОК-д танилцуулан шийдвэрлүүлэх.	2021 оны 3 дугаар сар	Ажлын хэсэг	Сумдын ажлын хэсэг
12	Коронавируст халдвар(КОВИД-19)-ын эсрэг вакциныг түгээх, дархлаажуулах үйл ажиллагаанд оролцох хүний нөөцийн судалгааг гаргах, томилон, үүрэгжүүлэх, баталгаажуулах.	2021 оны 3 дугаар сар	Эрүүл мэндийн газар	Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар
13	Коронавируст халдвар(КОВИД-19)-ын эсрэг вакциныг нэвтрүүлэх хүн амд чиглэсэн мэдээлэл, сургалт хийх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.	2021 оны 3 дугаар сар	Ажлын хэсэг	Эрүүл мэндийн газар
14	Коронавируст халдвар(КОВИД-19)-ын эсрэг дархлаажуулалттай холбоотой зорилтот бүлэг, иргэд, эрүүл мэндийн ажилтан, саын дурын ажилтан, албан хаагчдад зориулсан сургалт, сурталчилгааны материал, видео бичлэг бэлтгэн түгээх.	2021 оны 3 дугаар сар	Ажлын хэсэг	Эрүүл мэндийн газар
15	Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн үед яаралтай тусlamж, үйлчилгээ үзүүлэх багийг томилох, яаралтай тусlamжийн багцыг бэлтгэх.	Цэг бүрт бэлэн байлгах	Эрүүл мэндийн газар	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
16	Вакцин, хэрэгслийг нэгжүүдэд хүргэх.	дагалдах тээвэрлэн аюулгүй	Вакцин хүлээн авсан тухай бүр	Эрүүл мэндийн газар
				Бүх шатны Засаг дарга, Цагдаагийн газар

4.

1	2	3	4	5
17	Вакцин, дагалдах хэрэгслийг хүлээн авсан талаарх мэдээллийг илгээгч байгууллагад 24 цагийн дотор мэдээллэх.	Вакцин хүлээн авсан тухай бүр	Эрүүл мэндийн газар	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага

Хоёр. Дэмжлэгт хяналт

18	Вакцинжуулах үйл ажиллагааны бэлтгэл хангах болон явцын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх.	Тухай бүр	Бүх шатны Засаг дарга, ЭМГ-ын дарга	Мэргэжлийн хяналтын газар
19	Вакцинд хамрагдсан хүн амын дунд дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн тандалтыг хийж, мэдээллийн урсгалын дагуу мэдээлэх.	Тухай бүр	Эрүүл мэндийн газар	Бүх шатны эрүүл мэндийн байгууллага
20	Коронавируст халдварын эсрэг вакцины хамралтын мэдээг цахим программаар өдөр тутам авах нэгтгэх, орон нутгийн удирдлагын түвшинд танилцуулах.	Өдөр бүр	Ажлын хэсэг	Эрүүл мэндийн газар, бүх шатны эрүүл мэндийн байгууллага
21	Хамралтын түргэвчилсэн үнэлгээ хийх.	Дархлаажуулалтын явцад	Мэргэжлийн хяналтын газар	-

Гурав. Тайлагналт

22	Дархлаажуулалтын үйл ажиллагааны явцын болон төгсгөлийн тайланг аймгийн ОК-ын бүрэлдэхүүн болон ХӨСҮТ, ЭМЯ-д цаасан, цахим хэлбэрээр хүргүүлнэ.	Тухай бүр	Ажлын хэсэг	Сумдын Онцгой комисс
----	---	-----------	-------------	----------------------